

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-25

1. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан	5-7
2. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	7-20
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	20-25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Г.Дамдинням,
Д.Пүрэвдаваа, Б.Чойжилсүрэн;
Чөлөөтэй: З.Мэндсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг.

**Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний
албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан нар танилцуулав.

Сонсголын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд Бөхбатын Бат-Эрдэнийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн
баримт бичгийн хэрэгжилтийн тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор

С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын менежер Б.Саруул, ахлах аудитор И.Туяадарь, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Батжаргал, Да.Цогтбаатар, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт

Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан хариулж, тайлбар хийв.

Ц.Даваасүрэн: 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 2.“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 2.“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Х.Болормаа нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.8 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 22 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 50 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Амгаланг эрье. Төсвийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааныг үргэлжлүүлье. Ирц өмнө нь бүртгэгдсэнээрээ байна. Д.Батбаяр, Д.Батлут, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, Р.Батболд, Ж.Баясгалан, Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Б.Түвшин, Ж.Батжаргал, П.Ганзориг, П.Мөнхтулга, Да.Цогтбаатар гэсэн ирцтэй байна.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Нэгд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан. 2.Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-аас 25 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан. 3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 27, 28-ны төсвийн хүрээ, төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол хэлэлцэх эсэх байгаа. Эдгээр асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Эхний асуудалдаа оръё. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвших сонсголын тайланг хэлэлцэж эхэлье. Энэ чинь яах ёстой билээ, танилцуулах юм уу? Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2 Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүнд нэр дэвшүүлж Улсын Их Хурал томилохоор заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Төсвийн байнгын хорооны гишүүдээс санал болгосон нэр дэвшигч бүрээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Б.Бат-Эрдэнэ дэмжигдсэн. Ингээд чуулганы дэгийн тухай хуулийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын дагуу нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр явуулахаар товлож, Улсын Их Хурлын гишүүн Баясгалан сонсголыг даргалагч даргалж хэлэлцүүлсэн болно. Сонсголын тайланг, Улсын Их Хурлын гишүүн, сонсголыг явуулсан байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа Бөхбатын Бат-Эрдэнийг Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлсэн. Б.Бат-Эрдэнэ нь 1985 оны 85 онд төрсөн, 40 настай. 1993-аас 2000 онд ерөнхий боловсролын сургууль, 2003-2007 онд Хүмүүнлэгийн ухааны их сургууль, 2004-2010 онд Шинжлэх ухаан, технологийн их сургууль,

Барилгын инженер, архитектурын сургуулийг барилгын инженер мэргэжлээр төгссөн. Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Ажилласан байдал 2008 онд АПУ ХХК-д санхүүгийн мэргэжилтэн, 2008 онд Хөрөнгө оруулалтын Юу Ти И Эй ХХК-д судалгааны мэргэжилтэн, 2010 онд Хера Экуйпмент ХХК-д борлуулалтын мэргэжилтэн, 2010-аас 11 онд Мэргэжлийн боловсролын сургалтын газарт Санхүүгийн тайлан хариуцсан мэргэжилтэн, 2012-оос 16 онд Худалдан авах ажиллагааны газарт худалдан авах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, 2016 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт худалдан авах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, 2016-аас 17 онд Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, 2016-аас 18 онд Барилгын хөгжлийн төвд Материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, 2018-аас 22 онд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээд Борлуулалт хариуцсан дэд захирал, 2023-аас 24 онд Барилгын яаманд зөвлөх, 24-өөс 25 онд Кибер жаал ХХК-д санхүүгийн зөвлөх, 25 оноос одоог хүртэл Хөвсгөл аймгийн Мөнгөн-Од ХХК-д санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байгаа.

Түүнчлэн нэр дэвшигч нь Компанийн засаглалын үндэсний зөвлөлд компанийн засаглалын чиглэлээр, Койка-д санхүү худалдан авах ажиллагааны чиглэлээр, Сангийн яаманд худалдан авах үйл ажиллагааны чиглэлээр, Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах чиглэлээр тус тус мэргэжилтэнд хамрагдаж байсан болно. Нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалсан Улсын Их Хурлын гишүүн Баясгалан танилцуулна. Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлангийн танилцуулга. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Бөхбатын Бат-Эрдэнийг нэр дэвшүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл, мөн зүйлийн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонсголд оролцогчдыг бүртгэх болон нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авахаар сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

2.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, сонсголд Төсвийн байнгын хорооны гишүүд, нэр дэвшигч Бат-Эрдэнэ болон зарын дагуу бүртгүүлсэн нэг оролцогч оролцлоо.

3.Нэр дэвшигчийн сонголд сонгогч даргалагч нэр дэвшигчийн талаарх товч танилцуулж, үүний дараа нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа танилцуулж дууссаны дараа оролцогч Байнгын хорооны гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлсэн болно.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигч Бат-Эрдэнийг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзсэн болно.

Ц.Даваасүрэн: Баясгалан гишүүнд баярлалаа. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонголын тайлантай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу, нэрээ өгье? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт гэхээр чинь энэ чинь одоо зургаахан хүн болчиход байна шүү дээ, дуудчихъя, гишүүдээ байлгаж байгаад. Санал хураалт явуулчихъя. Бөхбатын Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд томилохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 26,7 хувиар дэмжигдсэнгүй. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэж дууслаа. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баясгалан чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

12.00 цаг

Хоёр.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан

Дараагийнхаа асуудалд оръё. Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор баталсан ЗГ-ын өрийн удирдлагын 2023, 2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж эхэлье. Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, мөн хуулийн 15.3, 15.4 дэх хэсэгт ЗГ стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 3 жилд нэг удаа, төрийн аудитын байгууллагын дүгнэлтийн хамтаар дараагийн стратегийн баримт бичгийн төсөл өргөн мэдүүлэх хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, тайлагнахаар заасны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор баталсан ЗГ-ын өрийн удирдлагын 2023, 2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Үндэсний аудитын газрын дүгнэлтийн хамт ЗГ-ын хуралдаанд ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.4 дэх хэсэгт Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх тайланд дүн шинжилгээ хийхээр зохицуулсан бол Үндэсний аудитын газрын дүгнэлттэй санал нэг гэсэн албан бичиг ирүүлсэн байна. Тэгэхдээ энэ бас нэг жоохон хуулийн зөрчилтэй асуудал болчиход байгаа юм. Тамгын газар бол зүгээр л нэг төсвийн эрх захирагч байхгүй юу. Тэгсэн

мөртөө бусад төсвийн эрх захирагч нарынхаа төсвийн асуудал дээр дүгнэлт гаргаж хэрхэвч болохгүй. Тэгэхээр энийг бид яаралтай өөрчлөхгүй болохгүй. 1 төсвийн эрх захирагч давуу эрх эдэлж болохгүй байхгүй юу. Тэр тусмаа Тамгын газар Үндэсний аудитын газрын бүх төсвийн эрх захирагч нарт гаргасан дүгнэлт, энэ өрийн удирдлагын хэрэгжилт гаргаж байгаа дүгнэлтэд ямар нэг дүгнэлт гаргаж болохгүй. Тийм учраас энэ Тамгын газрын зүгээс энэ дүгнэлт гаргахаас татгалзаж, санал нэг гэж санал ирүүлсэн нь энэ зөв. Тийм учраас энийг бид нөгөө энэ Төсвийн байнгын хорооны дэргэдэх төсвийн Тамгын газрын дэргэд болчихсон юм билээ. Энэ нөгөө нэг Төсвийн шинжилгээний алба энэ тэрийг өөрчлөхгүй болохгүй болчихоод байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй нэгдэх энэ ажлын хэсэг дээр энэ асуудлыг яаралтай бид шийдэх ийм шаардлагатай байна гэдэг нь эндээс харагдаад байгаа юм.

Би та бүхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. С.Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, С.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Д.Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Д.Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Б.Саруул Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Гантогтох. Сангийн яамны Санхүү бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, И.Туяадарь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Л.Эрдэнэбадрах НЗДТГ-ын, Тамгын газрын даргын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Тамгын газрын гэсэн дээр бичсэн.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023, 2025 оны стратегийн баримт бичгийн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд Жавхлан танилцуулна. Жавхлан сайд байгаа юм уу? Жавхлан сайдыг дуудъя. Байхгүй бол хойшлуулъя. Хэлсэн юм уу? Амарсайхан Шадар ирж байгаа юм уу? Амарсайхан сайд 5 дээр суучих уу? 5 номер Амарсайхан сайд ЗГ-ын стратегийн, өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн тайлангийн талаарх танилцуулгыг хийе. 5 номерын микрофон өгье. Дахиад өгье 5 номерын микрофон, танилцуулъя.

С.Амарсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 26 дугаар тогтоолоор 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр ЗГ-ын өрийн удирдлагын 2023-аас 25 оны стратегийн баримт бичгийг баталсан. Энэхүү стратегийн баримт бичгийн хүрээнд дунд хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр баримтлах үндсэн 6 зорилт, 23 хэрэгжүүлэх арга хэмжээ болон ЗГ-ын өрийн багцын 4 зорилт түвшнийг тодорхойлсон. Стратегийн баримт бичигт туссан зорилтуудын хүрээнд тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс товчхон дурдвал Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилт, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, хилийн үр бүтээмжийг сайжруулж, тогтвортой худалдааг дэмжих төсөл зэрэг бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслүүдийн санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэсэн билээ.

ЗГ-ын гадаад үнэт цаасны хувьд Сенчури 2, Сенчури 3, Сенчури 4 зэрэг нийт 1,5 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төлбөрийн тэнцэлд ирэх гадаад төлбөрийн дарамтыг бууруулсан. Мөн арилжааны нөхцөлтэй бондын үлдэгдлийг 23 оноос хойш 238 сая ам.доллараар бууруулснаар 2,5 тэрбум ам.доллар болсон байна. ЗГ-ын өрийн дотоодын ний бүтээгдэхүүнд эзлэх хувь буурч, төлбөрийн дарамт багассан, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд сайжирсан зэргийг үнэлэн зээлжих зэрэглэл тогтоогч олон улсын гол 3 агентлаг болох Fitch, S and P, Moodys зэрэг агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B plus нэмэх буюу B2 болгон нэмэгдүүлсэн.

Монгол Улс ХБНГУ-д төлөх байсан 29 сая еврогийн гадаад зээлийн төлбөрийг буцалтгүй тусламж болгон хөрвүүлж, эрүүл мэндийн салбарт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор өр хөрвүүлэх хэлэлцээрийг Германы KFW банк болон Глобал сантай байгуулсан. Зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгийн зах зээлд төгрөгийн суурь хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор 25 оны 4 дүгээр сараас дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлээд байна. Стратегийн томоохон төслүүд болох Чойбалсан дулааны цахилгаан станцын 50мвт-аар өргөтгөх төсөл, Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл зэрэг төслүүдэд ЗГ-ын өрийн баталгааг гаргасан. ЗГ-ын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг хэрэгжүүлснээр ЗГ-ын өр 2024 оны жилийн эцсийн байдлаар 33,4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 41,8 хувьтай тэнцэж, 22 оны жилийн эцсээс 18,7 хувиар, хүүгийн төлбөрийн төсвийн орлогын эзлэх хэмжээ 07 хувиар тус тус буураад байна.

ЗГ-ын өрийн удирдлагын 23-аас 25 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт 25 онд бүрэн дуусах бөгөөд Сангийн яамнаас стратегийн баримт бичгийн зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, өрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Та бүхэнд товч мэдээллийг танилцууллаа. Дэлгэрэнгүй мэдээлэлд асуулт, хариулт өгөхөд бэлэн байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Амарсайхан сайдад баярлалаа. Тайлантай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, асуулт? Батбаяр гишүүн, Батжаргал гишүүнээр тасаллаа. Батбаяр гишүүн асуултаа асууя.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аудитын газраас асуух асуулт байна. Самбууням дарга хариулах болов уу даа. Тэгээд энэ 2023-аас 2025 оны стратеги хэрэгжсэн 2023 онд 10, 2024 онд 11, нийтдээ 21 гэрээ байгуулсан гэж байгаа. Тэгээд үүний нэг нь болохоор энэ Улаанбаатар-Дарханы зам нэмэлт 2 эгнээ барих төслийн гэсэн ийм санхүүжилт байгаад байгаа. Энэ дээр аудитын байгууллага аудит хийсэн үү гэсэн ийм асуулт байна. Тэр дундаа энэ бүтээн байгуулалттай холбоотойгоор цементийг их хэмжээгээр авсан байх, хаанаас, ямар үнээр авсан бэ энэ дээр дүгнэлт хийсэн үү гэсэн нэг ийм асуулт байна?

Ц.Даваасүрэн: Аудитаас асуусан уу? 2 номерын микрофон аудит хариулъя. 3 номер, нэрээ, албан тушаалтайгаа хэлээд, тэгээд хариулъя.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Батбаяр гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын өрийн

удирдлагын 2023-аас 25 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудитын хүрээнд энэ Дарханы авто замыг өргөтгөх ажлын төслийн өрийн баталгааг ЗГ гаргаж ингэж хэрэгжүүлэхээр орсон байгаа. Энэ төслийн хөрөнгө оруулалтын ажлын тайлан бол Монгол Улсын ЗГ-ын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын нэгдсэн тайлангийн хөрөнгө оруулалтын тайлан дээр тусгаж тайлагнагдах болно. Одоогоор тайлан бэлэн болоогүй байгаа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тодруулах юм уу, болчихсон уу? Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: ЗГ-ын өрийн стратегийн хэрэгжилтийн тайланг гаргаж ирүүлж байгаа юм. Мэдээж бид ЗГ-ын нийт өр, түүнээс гадаад өр, гадаад өр дотор зээл, бондын эзэлж байгаа хувь гээд. Тэгээд энэ өнгөрсөн хугацаануудад сайжруулах чиглэлээр өр төлөх хэлбэрээр тодорхой арга хэмжээнүүд аваад ажилласан. Төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагуудад заагдсан хэмжээстээ бол одоо байж байгаа юм гэж ингэж ойлгоод байгаа. Тэгэхээр ер нь энэ саяын 3 жилийн хугацаанд энэ стратегийг хэрэгжүүлэх явцад бидэнд анхаармаар зүйлүүд ер нь юу байна гэж нэг?

2 дугаарт одоо бид Улсын Их Хурал дэмжээд соёрхон баталчихсан авч ашиглах зээлүүд нэлээдгүй байна. Энэ нь эдийн засгийн идэвхжилт, өсөлтөд нэлээн томоохон нөлөө үзүүлэх экспортын гол бүтээгдэхүүнүүдийн экспортын дэд бүтцийг сайжруулахтай холбоотой, үндэсний аюулгүй байдлаа хангахтай холбоотой, эрчим хүч үйлдвэрлэлтэй холбоотой гэдэг юм уу эсхүл энэ шатах тослох материалаа дотоодоосоо үйлдвэрлэхтэй холбоотой гээд олон томоохон төслүүдийн зээлийн эх үүсвэрүүд шийдэгдчихсэн. Авч ашиглах асуудал дээр Төсвийн хууль талаасаа ч, Тогтвортой байдлын хууль талаасаа ч, энэ стратеги талаасаа ч бидэнд тодорхой, тодорхой асуудлууд үүсээд байгаа. Тэгэхээр энэ гадаадын зээл, тусламжуудыг дан дамаа өөрийнхөө үйл ажиллагаагаар зээлийнхээ хөрөнгийг эргүүлээд хаачих гэдэг юм уу ийм боломжтой томоохон төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг ер нь юу гэж ойлгоод байна вэ? Төсөв дотроо оруулж авч явах ёстой юу эсхүл өөр гаргалгаа юмнууд байна уу гэдэг асуудал байгаад байна. Тэгээд үүн дээр одоо манай ЗГ ямар байр суурьтай байна вэ? Манай аудитынхан ер нь ямар байр суурьтай байна вэ? Үүн дээр би нэг тодорхой хариулт авчихмаар байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний асуусан асуултад эхлээд ЗГ, дараа нь аудит хариулъя. 7 номер, нэрээ, албан тушаалтайгаа хэлээд тэгээд хариулъя. Ер нь байна шүү дээ уг нь Их Хуралд ТНБД-аас дээш албан тушаалтан хариулах ёстой юм уг нь. Сүүлийн үед энэ байхгүй болсон юм байна. Ер нь тийм л болсон байна. Дандаа л нэг газрын дарга хариулаад л. Яагаад гэвэл улс төрийн ямар нэг хариуцлага хүлээхгүй улсуудыг хариулуулахгүй байгаагаар Их Хурлын дэгт зохицуулсан байдаг байхгүй юу. Энэ Их Хурал чинь энэ миний мэдэх 20-оод жилийн хугацаанд бүүр өндөрлөгөөс унасаар, унасаар байгаад ингээд дуусаж байх шиг байна даа. Тэгээд л нэг дуртай нь орж ирж хариулт өгч байдаг ийм л болсон байна. Цаашдаа энэ дээр анхаараарай. 7 номер.

С.Тулга: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга байна. Өрийн удирдлагын стратегийг авч хэрэгжүүлснээр бид дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх өрийн харьцааг тогтмол бууруулж ирсэн. 24 оны жилийн эцсийн байдлаар өрийн ДНБ-д эзлэх өрийн

үлдэгдэл 41,8 хувьтай байна. 25 оны 1 дүгээр улиралд 37,2 хувьтай, 1 дүгээр улирлын дүн маань 4 дүгээр улиралд өсдөг. Тэгээд 25 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр бид 41 хувьд өрнийхөө харьцааг ингээд бариад явах ийм зорилттой байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өрийн тааз ДНБ-ий 60 хувь гэж заасан байгаа. Бидний батлагдсан байгаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд энэ онд 55 хувь, дараа онд 50 хувь, тэгээд 27 онд 45 хувь, тэгээд 27 оноос цааш ер нь 45 хувь дээр барих энэ зорилтыг ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Зээл ашиглалтын хувьд 25 оны батлагдсан төсөв дээр гадаад зээл ашиглалтын хэмжээ нийт 1,5 их наяд төгрөг байгаа. Үүн дээр ингээд гадаад зээлийн ашиглалтад ингээд бүгд ороод явж байгаа.

Ц.Даваасүрэн: Хангалттай юу Батжаргал гишүүнээ? Юуг асуугаад байна шүү дээ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, нефтийн үйлдвэрийн зээлийн ашиглалтыг төсвийн зардалдаа тусгах ёстой тийм үү, нийт цэвэр зээлийн дүнд тусгах ёстой. Ингэхээр цэвэр зээлийн дүнд тусгахаар нөгөө төсөв алдагдалгүй байх ёстой зүйл чинь алдагдалтай болчихоод байгаа юм гэж ингэж. Тийм учраас энийг төсвийн гадуур бүртгээд явъя гэж. Яах вэ 14 онд билүү Ганбат дарга энэ дээр хариулаарай. Хэдэн онд билээ нөгөө эрчим хүч, төмөр зам 2-ыг нэг гаргаад ингээд явсан. Хэрвээ энэ 2-ыг ингээд оруулаад явна гэвэл төсөв алдагдалтай болно. Нөгөө талаараа ер нь одоо өөр бүтээн байгуулалт хийгдэх боломжгүй болох юм байна лээ. Бүх төсвийн цоорхойг энэ 2 нь ашиглалтаар эзэлчхэж байгаа учраас. Тэгээд энэ дээр нь нэг хариулаад явъя 4. 4 номерын микрофон. Яагаад тэгээд энэ төсвийн хэрэгжилтийн явцад энэ ашиглалт чинь гараад ирсэн юм бэ гээд байгаа шүү гишүүн.

Ж.Ганбат: Гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Гадаад зээлийн ашиглалтыг бид яг одоо 2025 оны төсөв Улсын Их Хурлаар батлагдахдаа алдагдалгүй батлагдсан байгаа. Бид одоо энэ гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд бид эсвэл орлогоо нэмэгдүүлж байж орон зай гаргана. Эсвэл бид зардлаа бууруулж байж энэ хэмжээгээр орон зай гаргана ийм байдалтай байгаа. Зүгээр яах вэ одоо сая тэр яригдаад байгаа Улсын Их Хурлын гишүүдийн ярьж байгаа, Сангийн яаман дээр очиж яг Улсын Их Хурлын гишүүд нэр бүхий гишүүд очиж ажиллаж гадаад зээлийн ашиглалт болон улсын төсвийн хөрөнгө оруулалт ер нь яг төсвийн нөхцөл байдлын талаар мэдээлэл Сангийн яамнаас албан ёсоор бид өгсөн байгаа. Бид яг одоо явж байгаа төслүүдийн хувьд яах вэ төсвийн бүрэлдэхүүнээс гаргахгүйгээр, яг тэр гишүүдийн санаа юу явж байгаа дээр төсөв дээрээ тусгай шаардлага дээрээ.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 4 номерын микрофоныг ахиад өгье.

Ж.Ганбат: Тусгай шаардлага дээрээ өөрчлөлт оруулаад яах вэ энэ эх үүсвэртэй буюу энэ гадаад зээлийн тэр 3 төслийн санхүүжилтийг явуулъя гэдэг ийм байдлаар ярьж байна гэж бид ойлгосон. Бидний 2025 оны төсөв алдагдалгүй батлагдсан учраас яг одоо энэ алдагдалгүй батлагдсан тохиолдолд бид үүнийг оруулахад 2-оос 3 их наядын эх үүсвэрийг бид гаргах зайлшгүй шаардлага үүсэж байгаа. 2-оос 3 их наядаар бид зардлаа бууруулж байж энэ дүнг санхүүжүүлэх ийм асуудал үүсэж байгаа. Гадаад зээлийн ашиглалт түрүүн таны хэлснээр нөгөө зардал талдаа дүн нь ороод тооцогддог учраас энэ нь төсвийн тэнцэл талдаа болон төсвийн тусгай шаардлагууд дээрээ нөлөөлөх ийм байдал үүсчхээд байгаа.

Ц.Даваасүрэн: Өмнө нь 25 оны төсөв оруулж ирэхдээ тэгээд энийгээ яагаад тооцоогүй юм бэ гээд гишүүдэд гол одоо гишүүдийн дургүйцээд байгаа нь тэр юм байна лээ. Яагаад өмнө нь тооцоогүй юм бэ? Гэнэт яагаад одоо энэ 2, 3 их наядын энэ зээлийн ашиглалт энэ 3 зээл дээр 3-уулан дээр нь яг яаж, яаж гарч ирээд байгаа юм бэ? Алин дээр нь нефть дээр нь хэд юм, Эрдэнэбүрэн дээр хэд юм, Сэлбэ дэд төв дээр хэд юм энийг нэг тодорхой болгочхооч? Энийг жоохон өөр өнцгөөс бүүр ингээд өрөө замбараагүй болгочхоод байгаа юм шиг ингээд айдас төрүүлсэн нийгэмд нэг ийм юм хаяад байгаа байхгүй юу. Зүгээр бүтээн байгуулалтаа хийх юм уу, үгүй юу гэдэг асуудал бол яг энэ дээр байгаа. Энэ дээр хариулъя 4.

Ж.Ганбат: Бид төсөв дээр гадаад зээлийн ашиглалт болон бусад энэ томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдэхдээ Өрийн хуулиараа болон Төсвийн тогтвортой байдлын хуулиар өрийн хязгаарлалтаараа бид түүн дээр хайчлагдаад яг тэр хүрээндээ багтаж байгаа юм. Энэ дээр өр дээр ямар нэгэн байдлаар өөрчлөлт орохгүй. Гол асуудал 2025 оны төсөв эхэлж ЗГ-аас өргөн баригдахдаа.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Өрийн шалгуур үзүүлэлтүүдээс хасахгүй байгаа юм байна шүү дээ. Хасахгүй.

Ж.Ганбат: Хасахгүй. Өрөө л дагана, шаардлагууд бол яг одоо хуулийн.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Зөвхөн төсвийн л одоо тэр нөгөө ерөнхий үзүүлэлтүүд, төсвийн алдагдал энэ тэрээс л.

Ж.Ганбат: Тийм, ер нь гол тийм болчхоод байгаа. Өр дээр бол ямар нэгэн асуудал байхгүй. Яг одоогийн байгаа хуулийн хүрээндээ тэр шаардлагуудыг нь бүрэн хангаад явна. Энэ дээр бол ямар нэгэн өөрчлөлт оруулах нөхцөл байдал, шаардлага үүсэхгүй. Гол асуудал 2025 оны төсөв Улсын Их Хурлаар батлагдахдаа алдагдалгүй төсөв батлагдсан. 2025 оны төсөв батлагдахдаа Улсын Их Хурал дээр алдагдалгүй.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 4 номерын юмыг дахиад өгчихье. Энэ нэлээн нийгэмд тийм эмзэг асуудал яваад байгаа учраас би тодорхой хариулт авъя гээд байгаа юм. 4.

Ж.Ганбат: Алдагдалгүй батлагдсантай холбогдуулан энэ саяын тэр 3 төслийн санхүүжилт бол сая хэлэлцээрийн явцад ялангуяа тэр газрын тосны үйлдвэр дээр бид Энэтхэгийн талтай хэлэлцээр хийгээд, энэ зээлийн ашиглалтаа нэмэгдүүлэх байдал ингээд үүссэн. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц дээр мөн зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх ийм шаардлагууд үүссэн учраас батлагдсан төсөв дээр үүнийг багтаах, үүнийг яаж зохицуулах вэ гэдэг ийм асуудал үүсчхээд байгаа юм. Тэгэхээр энэнтэй холбогдуулаад бид юун дээр зохицуулагдаж байгаа.

Юун дээр газрын тосны нэмэлт гэрээ саяын тэр Энэтхэгийн талтай хийсэн нэмэлт гэрээн дээр гадаад зээлийн газрын тосны үйлдвэрийн ашиглалт дээр сая 1 сард Улсын Их Хурлаар батлагдсан байгаа энэ нэмэлт гэрээний асуудал. Энэ газрын тосны нэмэлт гэрээ Улсын Их Хурлаар батлагдсан гэрээгээр 700 сая ам.доллараар гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр ингэж болж байгаа. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын гэрээ 2024 оны 11 сард ерөнхий гэрээ

санхүүжилтийн гэрээг Хятадын талтай зурсантай холбоотойгоор энэ гэрээ 2025 онд төсөв баталсны дараа Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын гэрээг хэрэгжүүлэх ийм шаардлага үүссэн учраас энэ 2 дээр гол ачаалал бол. Юун дээр чинь хэд билээ Эрдэнэбүрэн дээр, 253 сая доллар.

Ц.Даваасүрэн: Нийтдээ зүгээр энэ 2 дээр гэхэд 1 тэрбум доллар буюу 3 их наяд гаруй төгрөг юм байна шүү дээ, 3 их наяд гаруй юм байна. Тэгэхдээ хоёулаа яасан юм бэ гэхээр нөгөө төсвийн дараа, нөгөөдөх нь нөгөө Энэтхэгийн талтай төсөв батлагдсаны дараа шийдсэн, саяынх нь бас төсөв батлагдсаны дараа Хятадын талтай шийдэгдсэн ийм л 2 асуудал болчихоод байгаа юм байна шүү дээ тийм үү? Тэгэхдээ энэ дээр нэг зүйлийг ялгаж ойлгомоор байгаа юм. Өрийн шалгуур үзүүлэлт дээр энэ тусаад явах юм байна тийм үү, бүгд тусаад явна. Тэгэхээр өр дээр бол одоо авч хаях гэж байгаа юм алга юм байна. Зүгээр төсөвтөө багтаах тухай асуудал болчихоод байгаа юм байна шүү дээ. Төсөв нөгөө тэнцэл нь алдагдалгүй гэж байгаа учир. Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Өрийн удирдлагын тухай хуулиа хэрэгжүүлээд энэ амаргүй цаг хугацаанд өрнийхөө нөхцөлүүдийг сайжруулсан нэлээн гайгүй менежментүүдийг хэрэгжүүлсэн нь өнөөдөр төсөв дээр ирэх ачаалал юмнууд нь харьцангуй дарамтууд нь гайгүй байна гэж би ингэж үнэлээд хараад байгаа юм. Гэхдээ мэдсээр байж асуудлуудаа зохицуулах шийдлээ дэндүү хоцорч яваад байгаа юм биш биз дээ нөхөд өө? Бид Энэтхэгийн ЗГ-тай нэг аравны бараг гурав орчим тэрбум долларын зээлийн асуудал яригдаад, тэрнээс 240 хэдэн сая долларыг нь л ашигласан байгаад байгаа шүү дээ. Дээр нь дахиад 400 хэдийг нэмээд наадах чинь 1,7 тэрбум долларын асуудал байгаа. Уг хийгдэж байгаа объект 28 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулна гээд хэдүүлээ зорьчихсон. Наад Эрдэнэбүрэнгийн асуудал чинь мөн цаг хугацааныхаа хувьд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ганбат дарга хариулна. Энэ дээр байна шүү дээ ер нь зээлийн гэрээ батлагдаагүй байхад төсвийн ашиглалт дээр тусгаад явах ямар ч боломж байхгүй хуулийнхаа хувьд. Нөгөө талаараа яг энэ чинь 25 оны төсөв дээр яриад байгаа шүү дээ бид. Үнэхээр 700 сая, 250 сая ашиглалт хийгдэнэ гэвэл энэ чинь маш том бүтээн байгуулалт хийгдэх гээд байна шүү дээ. Энэ үнэн юм уу? 4 номер өгье. Ганцхан жилийн хугацаанд шүү дээ.

Ж.Ганбат: Газрын тосны үйлдвэр 1,7 тэрбум ам.доллароос 268 сая ам.долларыг нь ашиглагчаад байгаа. Үлдэгдэл 1,4 тэрбум ам.долларыг үлдсэн хугацаанд ашиглана. 2028 онд энэ газрын тосны үйлдвэрийг ашиглалтад оруулна гэж тооцож байгаа. Гол юм бол яах вэ нөгөө Энэтхэгтэй хэлэлцээр хийгээд тэр нэмэлт зээлийн гэрээгээрээ 700 сая ам.доллароор нэмэгдүүлчихсэн. Тэгээд одоо яг энэ гүйцэтгэл юмнууд нэлээн сайн явж байгаа. Тэгээд жил бүр 1 500 орчим сая ам.долларын ашиглалт ингээд гарахаар бид нарын нөгөө 2025 онд тооцчихсон гадаад зээлийн ашиглалтын дүндээ багтахгүй болчихоод байгаа энэ асуудал үүсээд байгаа. Ер нь зүгээр.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Ганбат дарга 500 сая чинь энэ 3 жил 3-уулаа ороод уу, ганцхан нефть дээр юм уу?

Ж.Ганбат: Нефть дээр би зөвхөн нефтийг ярьж байгаа.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр 25 онд 500 сая долларын ашиглалт хийж бүтээн байгуулалт бодитой хийгдэх нь байна шүү дээ нефт дээр тийм ээ? 4 номер.

Ж.Ганбат: Тийм, яг бодитойгоор 500 сая орчим долларын ажил хийгдэнэ. Бид яах вэ юун дээр газар дээр нь энэ тэр юуг нь үзсэн, Энэтхэгийн талтай ярьж байна. Газар тосны үйлдвэр нэлээн ажил нь эрчтэй явж байгаа. Энэ бол ашиглалт хамгийн багадаа 500 орчим сая ам.долларын ашиглалт бүрэн гарах юм байна гэж тооцоод байгаа.

Нөгөөдөх нь тэр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын асуудал 2024 оны 11 сард эцэслэж шийдэгдсэн. Энэ дээр 253 сая ам.доллар хийгдэнэ. Нийслэл дээр энэ онд 236 сая ам.долларын зээлийн ашиглалт хийгдэнэ гээд эд нарын тооцохоор яг одоо байгаа Улсын Их Хурлаар батлагдсан 2025 оны нийт зарлагын дүндээ болон гадаад зээлийн ашиглалтын дүндээ багтахгүй болчихоод л байгаа юм байгаа юм.

Ц.Даваасүрэн: Наадхыг чинь болохоор ингээд л хязгааргүй нэмэлт зээл авах гэж байна гэж ойлгоод байгаа байхгүй юу, ойлгуулаад байгаа байхгүй юу. Үгүй, энэ чинь угаасаа авах гэж байгаа нефтийн зээл, авна гээд төлөвлөчихсөн байгаа. Нөгөө Эрдэнэбүрэн чинь авна гээд төлөвлөчихсөн байгаа эд. Тэгэхдээ энэний ашиглалт нь сайжрах гээд байгаа юм байна шүү дээ. Энэ 25 онд ийм бүтээн байгуулалт. Хэрвээ төсвийн алдагдалгүй байна гээд энэндээ баригдаад юм уу, аль эсвэл энэ хуулийн өөрчлөлтийг хийхгүй бол ийм хэмжээний бүтээн байгуулалтууд хийгдэхгүй гэсэн үг юм байна л даа. Тэгж ойлголоо. Да.Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та өдрийн мэнд хүргэе. 10 аймагт дулааны станцын барилгын ажил Солонгосын Эксим банкны зээлээр эхэлсэн. Тэгсэн чинь зарим аймагт нь болохоор одоо болтол эхэлж чадаагүй, зарим ажил нь болохоор одоо явж байснаа гацаад зогсчихсон. Тэгээд сураг сонсохоор цаанаа очоод нөгөө Солонгосын Эксим банкнаас зээл авсан Солонгос компани нь дампуурчихсан гэсэн юм яригдаад байгаа юм. Тэгэхээр одоо бид энэ аймгийнхаа станцууд дээр жишээлэхэд цаашдаа яах юм бэ? Архангай ерөөсөө ажил нь эхлээгүй байгаа, Баянхонгор аймаг, Өвөрхангай аймаг 2 болохоор ажил нь эхлээд одоо гацчихсан. 25 оны төсөв дээр бид энэ дулааны станцын ажил явж байна гэж тооцоолоод Төсвийн тухай хууль дээрээ 2 дугаар хэлхээнийхээ мөнгийг тавьж өгөөд яваад байгаа. Тэгээд энэ дээр цаашид яах вэ гэдэг дээр нэг тодорхой хариулт хэрэгтэй байна.

Тэгээд 2 дугаарт болохоор одоо энэ явж байгаа зээл дээр чинь хүү нь тооцогдож байгаа юу? Бид одоо энийг хэрэглэхгүй байгаа, бүтээн байгуулахгүй байгаа энэ ажил дээр чинь бид зээлийнхээ хүүг төлөөд явж байгаа юу гэдэг нэг асуулт байна.

Тэгээд 3-д нь болохоор энэ хийгдэж чадаагүй ажлууд дээрээ хариуцлагын тухай асуудал яригддаг юм уу? Тэгээд энэ тайлан дээрээ биччихсэн байгаа юм. Бэлтгэл ажил хангагдаагүй байгаа ажлууд дээр нь жишээлэхэд ингээд зээл аваад, жишээлэхэд Архангайд чинь ерөөсөө газрынх нь маргаан хүртэл шийдэгдээгүй байхад бид зээл авчхаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр хариуцлага хүлээж, энэ бэлтгэл ажлаа хангаагүй ч юм уу, хангачихсан байх ёстой байсан ч юм уу энэ дээр нь нэг ийм хариуцлагын асуудал яригдсан зүйл байна уу гэсэн ийм 4 асуулт байна.

Ц.Даваасүрэн: Хариулах уу? 7 номер.

Б.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Гишүүний асуултад хариулъя. 10 аймгийн дулааны станцын гүйцэтгэгч Солонгосын Бюксан гээд компани байгаа. Энэ компани сая 25 он гарсны дараагаар өөрөө энэ дампуурлаа зарлах тухай Солонгосынхоо шүүхийн байгууллагад хандсан байгаа. Бид Эксим банкт хийсэн уулзалтаар энэ шүүхийн процесс эцэслэн шийдэгдэх хүртэл энэ компанийн санхүүжилт төлбөрийг Эксим банкнаас бүрэн зогсоосон байгаа. Энэ зогсоосонтой холбоотойгоор компани одоогоор ямар нэгэн ажил хийхгүй байгаа. Бидний энэ бол Архангай аймгийн асуудал өөрөө шүүхийн маргаантай байсан. Архангай аймгийн шугам сүлжээний асуудал хувийн хэвшил дээр байж байгаад одоо тэгээд энийг ЗГ луу шилжүүлэх асуудал нь шийдэгдээд, энэ төсөл одоо уг нь аймаг дээрээ хэрэгжилт нь эхлэх асуудал бүрэн болсон. Харамсалтай нь энэ гүйцэтгэгч компанийн санхүүгийн асуудлаас болоод одоогоор ингээд төсөл түр зогсонги байдалд орсон.

Гэхдээ Эрчим хүчний яамнаас энэ гүйцэтгэгч компанийн санхүүгийн асуудал энэ Солонгосын шүүхийн байгууллагаар шийдэгдэх хүртэл хугацаанд гүйцэтгэгч компанитай ажлаа үргэлжлүүлэх үү, үгүй юу гэдэг асуудал дээр судалгаа хийгээд явж байгаа юм байна лээ. Гэхдээ ер нь манай Сангийн яамны байр суурь энэ компанитай аль болох хурдан гэрээгээ цуцлаад, дараагийн санхүүгийн чадвартай компаниа шалгаруулаад, ингээд төслийг богино хугацаанд дуусгах шаардлагатай гэдгийг удаа дараа хэлж, Эксим банканд энэ талаар хүсэлтээ хэлсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Энэ чинь Солонгосын компаниудын дунд зарлана гээд, тэгээд Солонгосын компани нь өрсөлдөгчгүй, эхлээд 2 ирснээ болиод, дараа нь ганцхан компани ирээд тэгээд л ийм юм болсон шүү дээ. Тэгээд Солонгосын талд тэр Эксим банканд нь энэ асуудлаа сайн хэлэх хэрэгтэй. Өөрсдөө эд нар чинь ... objection өгч байгаа шүү дээ. Тэгээд шахаад л, ганцхан компани ирүүлээд л зөвхөн Солонгосын компаниудын дунд гэхээд л. Тэгээд одоо ийм нөхцөл байдал үүсэж байна. Энэ одоо хэдэн 10 жил давтагдаж байна шүү дээ. Нэмэлт, дутуу хариулсан гэж байна. Цаашдаа яах вэ гээд байна? Зээлийн хүү, зээлийн ашиглалт нь яг чи хэд болчихоод байгаа юм бэ, чи дахиад зарлая гээд байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ чинь тийм асуудал үүснэ шүү дээ. Хэдийг нь энэ компани ашиглачхав, хэд үйлдэв, хариулъя. Аудит нэмээд яачхаарай. Эхлээд 7, дараа нь аудит.

Б.Ганзориг: 10 аймгийн дулааны цахилгаан станцын төслийн нийтдээ ингээд 3 багц дээр хуваасан байгаа. Яг нийтдээ бид нарын өнөөдрийн байдлаар олгосон санхүүжилт зөвлөх үйлчилгээ дээр 5,4 сая доллар, Баянхонгор аймаг ер нь багц 1 дээр бол 4 аймаг байгаа. Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан гэсэн 4 аймгийг нийлүүлээд нэг багц болгосон. Энэ аймгууд дээр төсөвт өртөг нь аймаг бүр дээр харилцан адилгүй. Гэхдээ дунджаар 12 сая доллар байгаа нэг аймгийн өртөг. Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгуудын хэрэгжилт бүгдээрээ 40-өөс дээш хувьтай явж байгаа. Үүн дээр санхүүжилтүүд нь яг хэрэгжилттэйгээ уялдаад гарсан байгаа. Багц 2 дээр Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар аймгууд явж байгаа. Говьсүмбэр болон Сүхбаатар аймгийн төсөвт өртөг бусад аймгуудыгаа бодвол арай бага. Хэнтий аймгийнх 14 сая.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Аудит 2 номер, гүйцээх юм уу? 7 гүйцээчихье.

Б.Ганзориг: Тэгэхээр Хэнтий аймгийнх 14 сая ам.долларын гэрээтэй. Хэнтий аймгийн гүйцэтгэл 45 хувьтай, Говьсүмбэр аймгийн гүйцэтгэл 45 хувьтай, Сүхбаатар аймгийн дулааны станцын гүйцэтгэл 50 хувьтай явж байгаа. Гүйцэтгэлтэйгээ уялдаад санхүүжилт нь гарсан байгаа.

Багц 3 буюу Төв болон дунд аймгийнх санхүүжилтүүдээ ер нь 40-өөс дээш хувьтай авсан байна. Төв аймгийн багцын Төв аймгийн дулааны станцын гэрээний үнийн дүн 13,8 сая доллар байгаа. Дундговь аймгийнх 10 сая доллар байгаа. Уг нь ингээд ТЭЗҮ-ээрээ Архангай аймагт хуваарилагдсан үлдэгдэл мөнгө 13,2 сая ам.доллар байгаа. Гэхдээ одоо саяын гүйцэтгэгч компани маань өөрөө төсөвт өртгийн нэмэгдлийн асуудлыг ярьсан. Үүнийг захиалагч яамнаас шийдвэрлэх боломжгүй гэдэг байдлаар магадалшгүй ажлынхаа төсвийн хүрээнд шийдвэрлэх.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ямар ч гэсэн ашиглагдсан байна. Тэгэхдээ үлдсэн ажил чинь үлдсэн зээлийн хэмжээнд одоо хүрэх үү, үгүй юү гэдгийг анхаарахгүй болохгүй юм байна. 2 номер. Чи тодруулчих дараа нь. 2 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Үндэсний аудитын газар Ерөнхий аудитор Магнайсүрэн. Манай аудитын баг энэ өрний удирдлагын стратегийн хэрэгжилт дээр ажиллаад, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсан сэдвийн дагуу ажиллаад, тэгээд цаг хугацаанд нь тайлангаа өгсөн байж байгаа. Энэ тайланд 14 чиглэлээр дүгнэлт гаргаад, нийтдээ 8 зөвлөмж холбогдох ЗГ-ын гишүүд болоод, холбогдох байгууллагуудад өгсөн байдаг. Энэ 8 зөвлөмжийн нэг зөвлөмж нь яг саяын Цогтбаатар гишүүний асуултад асуусан ийм асуудал байж байгаа. Өөрөөр хэлбэл тайлангаас үзвэл 2023 онд 12,1 тэрбум төгрөг, 24 онд 39,4 тэрбум төгрөгийг энэ зээлийн ашиглагдаагүй зээлийнхээ хүүд төлсөн байна.

Ц.Даваасүрэн: 2 номерыг үргэлжлүүлье. Юуны ашиглагдаагүй зээлд гэнэ вэ?

С.Магнайсүрэн: Гадаад зээлийн гэрээ хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн одоо хэмжээнд тооцогдох хүүгийн шимтгэлд.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Аль зээл дээр?

С.Магнайсүрэн: Ашиглагдаагүй, одоо ашиглаж амжаагүй, ашиглаж, зээлийн хүү нь шугам нь нээгдчихсэн, тэгээд эндээ хүү төлөгдсөн, энэ хүү нь нийтдээ 2 жилийн хугацаанд 51,5 тэрбум төгрөг болжээ.

Ц.Даваасүрэн: Энэтхэгийнх үү, аль зээл үү?

С.Магнайсүрэн: Биш ээ, нийтдээ, нийт улсын хэмжээнд. Тийм учраас цаашдаа саяын жишээлбэл зээл жишээлбэл багтаад явж байх жишээтэй. Цаашдаа ингээд гадаад зээлийг авч хэрэглэхдээ энэ төсөл хөтөлбөрийн, хэрэгжүүлэх төслийнхөө бэлтгэл ажлыг сайтар хангах шаардлагатай гэсэн ийм зөвлөмжийг энэ тайланд тусгасан байж байгаа.

Ц.Даваасүрэн: Яах вэ ингээд шугам нээгдэнгүүт хүү тооцогдоно гэдгийг зээлийн хэлэлцээр дээрээ ашиглагдсан тохиолдол гэдгээр л хэлэлцээрээ сайн хийх хэрэгтэй байхгүй юу. Би зүгээр сонсохдоо Энэтхэгийнх дээр тийм юм байна гэж сонссон. Шугам нээгдчихэнгүүт хүү тооцогдоод. 7 номер түрүүний асуултаа хариултыг нь гүйцээе.

Б.Ганзориг: Энэ Солонгосын Эксим банкны зээлийн хүү дээр яг ашигласан дүн дээрээ төлж байгаа юм хүү төлж байгаа юм. Тийм. Зөвхөн ашигласан дүн дээр. Түрүүний ашиглагдаагүй үлдэгдэл дээр төлж байгаа дүн гэдэг нь болохлоор бид зээлийн гэрээ байгуулчхаад жишээлбэл 300 сая долларын зээлийн гэрээ байгуулчхаад түүнээсээ 50 саяыг нь ашиглавал бид 50 сая дээр нь зээлийн хүүгээ төлнө. Эх үүсвэрээ баталгаажуулаад түүнийгээ ашиглагдаагүй үлдэгдэл одоо 250 дээрээ бид Commitment Fee гэж төлдөг тэр дүнг ярьж байгаа.

Ц.Даваасүрэн: Сая ашиглаагүй, шугам нь нээгдчихсэн байхад хүү төлсөн гээд байна шүү дээ. Тэгээд би тодруулаад байгаа нь аль зээл дээр тийм гэрээ хийгдчихэв гээд байгаа байхгүй юу. Хариул даа 7.

Б.Ганзориг: Тэр болохлоор тухайлсан зээл биш, нийт зээлийн багцынх нь хувьд ярьж байгаа юм гишүүнээ.

Ц.Даваасүрэн: Тийм зээлүүд байгаад байгаа юм уу? Одоо ингээд ашиглаагүй байхад ашиглах эрх нээгдчихлээ шүү дээ тийм үү, тэгчхээд хүү тооцоод байгаа зээлүүд байгаад байгаа юм уу? Тэр ямар зээлүүд дээр тийм гэрээ хийгдчихэв? 7.

Б.Ганзориг: Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр хүү тооцохгүй байгаа, шимтгэл авч байгаа бүх зээлдэгч байгууллагууд. Тэр шимтгэлийг бичээд байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Шимтгэл юм байна тийм ээ?

Б.Ганзориг: Commitment Fee гэж байгаа тэр болохлоор хүү биш. Хүүг бид зөвхөн ашигласан дүнгээсээ төлж байгаа.

Ц.Даваасүрэн: Ойлголоо.

Б.Ганзориг: Солонгосын хувьд 0,15 хувийн нэн хөнгөлөлтийн хүүтэй.

Ц.Даваасүрэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Тодруулах юм уу? Цогтбаатар гишүүн тодруулчихъя.

Да.Цогтбаатар: Энэ Солонгосын Эксим банкны зээл дээр чинь бэлтгэл ажлаа хангаж чадаагүй байхад нь бид зээл авчихсан. Тэгээд одоо жишээлэхэд шугамаа нээлгэчихээд хэрэглэж чадаагүй чинь бид нарын хохийн асуудал буюу бид нарын өөрсдийнх нь хариуцлагын асуудал яригдаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр хариуцлага алдсан хүмүүстэйгээ хариуцлага тооцож чадаагүй бол энэ Солонгосын Эксим банк, тэгээд тэрний цаадах гүйцэтгэгч байгууллага Бюксан ч юм уу тэд чинь энэ өнгөрсөн жил бид төсөв хэлэлцэж байх үед л яригдаж байсан асуудал одоо болтол яг тэр чигээрээ яваад байгаа байхгүй юу. Нэг ч алхам урагшлаагүй, үр дүн гараагүй. Тэгээд бид хохироод, Монгол Улс өөрөө хохироод

байна гэдгийг тооцохгүйгээр энд орж ирэхээрээ уран цэцэн юм ярихгүйгээр бидэнд нэг үр дүн гаргаад өгөөч гэж та бүгдээс хүсэх гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Ер нь анхаараарай. Энэ Солонгосын зээлүүд дээр. Одоо тэр нөгөө орон сууцын зээл энэ тэр гайгүй явж байгаа биз, тэрийгээ та анхаараарай. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгье. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: 3 тодорхой санал байгаад байгаа юм. 1 дүгээрт бид энэ дотоодын төсөвтэй холбоотой, тогтвортой байдалтай холбоотой, тусгай шаардлагатай холбоотой хууль тогтоомжуудаараа тодорхой хэмжээний хязгаарлалтууд хийж өгч байгаа. Энэ бол яах аргагүй эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хоорондын уялдааг хангаж, энэ нэг зөв чиглэлдээ явах үүднээс хийгдэж байгаа зүйлүүд. Гэтэл үүндээ нийцэж байгаа нь энэ гээд асуудлаа хүндрүүлээд байгаа юмнууд байгаад байна. Үүнийгээ засах талаар их тодорхой арга хэмжээнүүдийг авмаар байна. Саяын одоо энэ Их Хурлын гишүүд нэг хууль санаачлаад, нөгөө талд нь нэг хэсэг гишүүд өөр байр суурьтай байгаад байгаа явдал буруу биш, угаасаа хууль нь тийм нэг.

2 дугаарт тэр бүтээн байгуулалтын ажлуудыг явуулах шаардлага байна уу гэвэл байна. Тэгэхээр энийг бид ярих цаг нь болчихсон гэсэн үг байхгүй юу. Хэн нэгнийг буруутгах биш, ярих цаг нь болчихсон. Ярьж энийгээ зөв шийдэлд орох ёстой. Би төсвөөс гаргачихна гэж харахгүй байгаа. Хамгийн гол нь ямар шийдлийг олж үүнийг зөв явуулах вэ гэдэг нэг ийм асуудал байгаа юм гэж.

2 дахь зүйл энэ гадаадын зээлийн ашиглалт дээр бид бодохоор зүйлүүд байгаад байгаа юм үнэнийг хэлэхэд. Авч ашигласан зээлдээ хүү төлж байгаа, авч ашиглаж чадаагүй эрх нь шугам нь нээгдчихсэн асуудлууд дээрээ шимтгэл нэртэй үндсэндээ бага хүү, хувьтай хүү төлөлт л явж байгаа байхгүй юу. Гэтэл энэ нь чухам хэнээсээ болсон юм бэ гэдэг асуудлаа их зөв дүгнэхгүй болохгүй. Дам дамаа наад Солонгосын талын зээлийн асуудал чинь мөн ч олон жил яригдаж байж асуудал шийдэгдсэн. Тэгээд өөрийнх нь одоо эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэгч нь шалгарсан, тэрнийх нь буруутай үйл ажиллагаанаас болоод энэ үйл ажиллагаа нь явахгүй байгаа. Тийм учраас дутуу үйлдвэрлэл гэдэг юм уу даа авч ашиглаад хэрэглэчихсэн нэг хэсэг зээл байна. Бараг тэрэнд хүү төлмөөргүй байгаа. Авч ашиглаж чадаагүй байгаадаа шимтгэл төлмөөргүй байгаа. Бидний буруу биш байхгүй юу. Тэдний өөрсдийнх нь шалгаруулсан үйл ажиллагаа тэр цаад компанийнх нь чадамжтай холбоотой ийм асуудал үүсчхээд байгаа. Үүнийг ер нь цаашид энэ өрийн удирдлага, энэ зээл авч ашиглалтын гэрээ хэлцэл юмнууддаа сургамж авч, ер нь зөв шийдэл гаргах тал дээр нь бид бодож ажиллах ёстой болов уу гэсэн би нэг ийм санаа гарч ирээд байгаа юм. Үүнийг одоо зөв хармаар байна.

Ер нь та хэд энэ сая тайлан оруулж ирэхдээ ар дээр нь нэг санаа оруулж ирсэн байна лээ. Тэр нь юу байна вэ гэхээр зэрэг дотоодын бондын ашиглалтыг нэмэгдүүлэх, гадаадын зээлийн ашиглалтыг гэдэг юм уу авалтыг бууруулах чиглэлээр юм яриад байгаа юм. Өнөөдөр бид тийм хэмжээний чадамжид хүрсэн юм уу? Ингэвэл эдийн засгаа дэндүү их агшаах тухай, жоохон байж байгаа боломжоо бодит салбар буюу эдийн засгийн салбараасаа түрүүлээд дотоод бондоороо өөрсдөө хумиад авчих тухай. Энэ бол үндсэндээ нэлээн адармаатай зүйл шүү. Ер нь би та нарын энэ өрийн стратегийн чинь цаашдын барих гээд байгаа бодлого дээр нэг иймэрхүү санаа илэрхийлэгдэх гээд байгаа юм биш биз

дээ? Ар дээр нь гарч ирсэн дүгнэлтэд ийм зүйл орж ирээд болж өгөхгүй байна гэдэг ийм санаа байгаад байгаа юм. Тийм учраас үүнийг нэлээн сайн бодож, зөв дүгнэлт хийж, зохистой харьцааны тухай асуудлаа шийдэх тухай л ойлголт байгаа. Үүнийг би бодооч л гэж ийм зүйл хэлмээр байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн үг хэллээ, анхаараарай. Энэ Солонгосын зээл чинь одоо ёстой үлгэр шиг түүхтэй юм шүү дээ. Тэгээд сүүлд нь нэг юм ашиглагдахаар болсон чинь манайд байгаа Дулааны станцын Булганы дулааны станцын хувийн хэвшил барьсан үнээс 2 дахин шүү, 2 дахин өндөр үнэтэй. Манайд баригдсан дулааны станцуудаас 2 дахин өндөр үнэтэй. Тэгээд өнөөдөр мөнгө нэхээд байна гэж яриад байна шүү дээ хүрэлцэхгүй боллоо гээд. Тэгээд энэ талаар Солонгосын талтай яримаар юм байна лээ. Тэгээд энэ нэг компаниудыг шалгаруулж байгаа нь зөвхөн Солонгосын компаниудын дунд. Тэгээд 1 компани хүрээд ирнэ, тэгээд тэр нь дараа нь ингээд ийм байдал үүсгээд байна гэдгийг Сангийн яам ярих ёстой байх шүү. Бид бэлгийн морины шүдийг үзэхгүй гэдэг шиг тэгээд л тэр нөгөө тулгасан өндөр үнээр нь 10 аймаг дулааны станцтай болж байвал яах вэ гээд ингээд л яваад байгаа байх.

2-т ер нь энэ зээлийн ашиглалтын асуудал багтахгүй болоод байгаа гэдэг чинь асуудал байна гэсэн үг. Батжаргал гишүүний хэлээд байгаа үнэн. Асуудал үүсчихлээ гэж. Тэгэхдээ энийг ашиглахгүй гэвэл хөрөнгө оруулалт байхгүй гэсэн үг шүү дээ. Тэр Эрдэнэбүрэн чинь босохгүй, нефтийн үйлдвэр чинь босохгүй. Ашиглах зайлшгүй шаардлага байна. Тэгэхээр энийг яаж авч явах юм бэ гэдэг асуудал байсан байхгүй юу. Энийг бид уг нь шийдсэн, 2010 онд шийдсэн. Хөрөнгө оруулалтын банк гээд байгуулсан байхгүй юу. Ийм том зээлүүдийг төсөвт багтахгүй байгаа зээлүүдийг төсвөөс гадуур авч явъя гээд энэ банкиг байгуулсан. Дараа нь ялагдсаны дараа юу гэсэн гэхээр төсвийн гадуур дахиад төсөвтэй боллоо гээд нөгөө энийг санаачилсан улсууд нь нөгөө Хөрөнгө оруулалтын банкигаа байхгүй болгох юм руу явсан байхгүй юу. Нөгөө нам нь ялчхангуут нөгөө намынхаа эсрэг юм ингээд л. Манайх ингээд улс төржөөд байдаг юм байна лээ. Өөрсдөө байгуулчхаад ийм том төслүүдийг ингэж явуулъя гэж байгуулчхаад дараа нь 2 төсөвтэй боллоо, энийгээ байхгүй болгоё гээд суучихсан байхгүй юу. Тэгээд Хөгжлийн банк нь ч олигтой юм байхгүй.

Тийм учраас энэ бусад улс орнууд яаж зохицуулж байна вэ гэвэл Хөгжлийн банкаараа л зохицуулж байгаа шүү дээ ийм том, дэд бүтцийн том төслүүдээ. Манайх шиг ингэж төсөвтөө авч орж ирээд, төсөв нь тэрийг нь тусгах боломжгүй, шалгуур үзүүлэлт нь хангагдахгүй болчихдог тийм асуудал гарахгүй байгаа нь тэнд тэгж л яваа байхгүй юу Хөгжлийн банкаараа дамжаад. Манайх бүх юмыг төсөв дээрээ авч явна гэвэл байхгүй. Тэгэхээр асуудал байна уу гэвэл байна гэсэн үг. Тэгэхээр би ЗГ-аас тэр юу Эксим банкны асуудал оруулж ирэх гэж байгаа гэж би ойлгосон. Түүндээ ер нь энэ нэг хөрөнгө оруулалтын томоохон дэд бүтцийн төслүүдийнхээ санхүүжилтийн асуудлыг төсвөөс гадуур ЗГ-ын баталгаа гаргаад яаж авч явах юм бэ гэдэг юмаа шийдэхгүй бол энэ чинь өөрөө янз бүрийн ойлголтыг нийгэмд төрүүлээд байгаа байхгүй юу. Тэгээд энийг анхаарах шаардлага байна гэж.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор баталсан ЗГ-ын өрийн удирдлагын 2023, 2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж дууслаа. Ер нь гишүүд чуулганаар хэлэлцэх энэ тэрд анхаарах юм тэр стратегийн баримт бичигт бид

ямар, ямар шалгуур тавьсан байсан тэр шалгуурууд нь яаж, яаж биелсэн тухай л уг нь яримаар байгаа юм л даа. Бид нэг зээлийн ашиглалтын тухай л яриад байгаа юм. Шалгуураа хэр биелснээ ерөөсөө ярьсангүй. Энэ дээр анхаарна биз дээ.

12.50 цаг

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

3 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төслийн тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх хэсгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөхөөрөө биз дээ, арай өөрчлөлт орчихсон юм уу? Аудитаас бусад нь байна. С.Амарсайхан гишүүн Монгол Улсын Шадар сайд, Ж.Дэлгэрсайхан Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Р.Ринчинбазар Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Л.Энх-Амгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Л.Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, М.Санжаасүрэн Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн Яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Отгондэмбэрэл, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.4 дэх заалт, Төрийн удирдлагын тухай хуулийн 14.2 дахь хэсэгт Засгийн газар стратегийн баримт бичиг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 5 сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурал жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор хэлэлцэн батлахаар заасан. Үүний дагуу ЗГ-аас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн төслийг, мөн ЗГ-ын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичгийн тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг та бүхэнд өргөн мэдүүлснийг тараасан байгаа. Тогтвортой байдлын тухай хуулийн 16^{5.2}-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төслийн тухай хуулийн төсөл болон стратегийн, ЗГ-ын өрийн удирдлагын 26, 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын төслийн, тогтоолын төсөл байх тийм

ээ, тогтоолын төслийн талаар Тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 64.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд дүн шинжилгээ хийж ирүүлсэн. Би түрүүн энэ талаар хэлсэн. Энэ болохгүй зүйл. Аудитаа давсан Их Хурлын Тамгын газар гэж байж болохгүй байхгүй юу. Тийм учраас Тамгын газар зөвхөн Их Хуралд туслалцаа үзүүлэх байгууллага. Тэрнээс биш дүн шинжилгээ өгдөг, төсвийн эрх захирагчдыг зохицуулсан ийм зохицуулалт хийх эрх Тамгын газарт байхгүй. Тэгээд энийг цаашдаа хуулиас өөрчлөлт хийхгүй бол болохгүй зүйл болсон байна гэдгээ бид анхаарах ёстой. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон Засгийн газрын өрийн удирдлагын 26, 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Амарсайхан сайд, Шадар сайд танилцуулна. 5 номерын микрофон.

С.Амарсайхан: Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-оос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулан та бүхэнд танилцуулж байна. Манай эдийн засаг 2024 онд 4,9 хувиар өсөж, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 80 их наяд төгрөгт, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6898 ам.долларт хүрсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6 хувь, 2027-гоос 28 онд 6,5 хувь тус тус байхаар тооцож тусгалаа.

Дунд хугацаанд зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, алт зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт тогтворжих бол, хөдөө аж ахуйн салбар, худалдаа, үйлчилгээ, боловсруулах болон барилгын салбарын өсөлтийн нөлөөгөөр уурхайн бус салбарын өсөлт 6 хувиас дээш байхаар тогтвортой хадгалагдахаар тооцож байна. Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээг 2026 онд 33,5 их наяд төгрөг, 2027 онд 35,6 их наяд төгрөг, 2028 онд 39,1 их наяд төгрөг байхаар тусгалаа. Тодруулбал нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагыг 2026 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 31,7 хувь, 2027 онд 30,4 хувь, 2028 онд 29,6 хувь болж үе шаттай буурахаар төлөвлөсөн болно.

Төсвийн зардлын нийт эдийн засаг дахь харьцааг ийнхүү хязгаарласнаар цаашид эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулах, ингэснээр зээлийн хүү буурах суурь нөхцөл бүрдэх, эдийн засаг дахь төрийн оролцоо багасах, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх зэрэг бодит ач холбогдолтой гэдгийг энд тэмдэглэн хэллээ. Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-аас 28 онд алдагдалгүй байхаар, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай, 2026-аас 27 онд тус тус дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар тооцож тусгасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан болно. Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн Сангийн яамнаас, дагуу Сангийн яамнаас ЗГ-ын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна. Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичгийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн санхүүжилтийн боломжит хувилбарууд болох ЗГ-ын өрийн багцын эрсдэлийн үзүүлэлтүүдийг тооцож боловсруулсан. ЗГ-ын өрийн дунд хугацааны төсөөллөөр ЗГ-ын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2026-аас 28 онд 40-өөс 42 хувь орчимд тогтворжих төсөөлөлтэй байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Амарсайхан сайдад баярлалаа. Төсвийн хүрээний мэдэгдэл, ЗГ-ын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн тухай тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулна гишүүдээ дуудъя. 2 санал хураалт юм байна, гишүүдээ дуудъя.

Энэ тэгээд төсөв алдагдалгүй баталдаг дэлхийд хэдэн орон байдаг вэ гэдгийг бид бодох ёстой байхгүй юу. Манай Монголчууд ингээд нэг сенсац хөөж, тэрийгээ дагаж савдаг нэг тийм нэг тогтвортой бодлогогүй улс юм. Арваадхан орон байгаа байхгүй юу даа. Ингээд нэг их мундаг төсвийн алдагдалгүй орон боллоо гээд л хашхиралдаад л, алга ташаад л. Одоо тэгээд хар л даа. Нөгөө зээлээ ашиглаж чадахаа больчихсон, нөгөө Энэтхэгийн зээлээ, нөгөө Эрдэнэбүрэнгийн зээлээ ашиглаж чадахгүй болчихсон. Энэ бидний бодлого сул явдгийн гай шүү дээ. Тэгээд нэг тийм сенсац хөөж амьдарна. Нэг юм цацаад л, тэгээд л тэрнийхээ хойноос баахан балбачих нь. Нөгөөдхийг нь нийгэм тийм гээд хүлээгээд авчихна. Нэг их л мундаг юм хийсэн юм шиг. Үгүй ээ мундаг юм хийсэн юм бол энэ Монгол орон чинь мундаг л байна биз дээ. Аль эрт одоо тэр Азийн бар болох байсан, болоогүй л байна шүү дээ.

Тэгээд бидний мундаг гэж ярьж байгаа, хийж байгаа юм нь эргээд бид нарын хүзүү ороогоод байгаа байхгүй юу. Дийлэнх улс орон төсөв нь алдагдалтай л байна шүү дээ. Тэгээд төсвийн алдагдлаа эх үүсвэр талдаа зээлээ тавиад л санхүүжүүлээд явж байна шүү дээ. Зээл авдаггүй компани, зээл авдаггүй улс орон гэж юу байдаг юм бэ? Энэ нэг хийрхсэн улс төржилтөөс салж, нэг жоохон бодлоготойнхон тийм төртэй явахгүй бол энэ Монгол ерөөсөө ингээд л яг шаварт унасан чигээрээ л байх юм байна. Ямар ч ахиц дэвшил байхгүй. Өөрсдийгөө чөдөрлөсөн, хумьсан бүх юмаа. Харин яах вэ одоо энэ орж ирж байгаа Төсвийн хүрээний мэдэгдэл дээр тэр юу төсвийн хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсныг бууруулъя гэж байгаа бол зөв шүү. Энийг бууруулах хэрэгтэй. 2021 онд 11 их наяд байсан төсөв 3-хан жилийн дотор 35 их наяд болсон байхгүй юу. Энэ бол байж болохгүй зүйл. Энэнээс чинь болж энэ инфляц явж байгаа, юмны үнийн өсөлт явж байгаа, мөнгөний хэвлэлт явж байгаа.

Тэгэхээр одоо цаашдаа бидний нэг анхаарах юм бол Их Хурлын түвшиндээ, ЗГ-ын түвшиндээ ч тэр төсвийн хүрээ хэлэлцэж батлахад бидний анхаарах юм төсвийг ахиж тэлж болохгүй. Ахиж ерөөсөө тэлж болохгүй. Энэ дээрээ хэдүүлээ Төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг хэлэлцэх дээр нэлээн анхаараад ингээд явъя.

гишүүдээ дуудъя, 2 санал хураалт байна. Тэгээд 5 номерын микрофоныг өгчих протоколд тэмдэглээд авчих.

С.Амарсайхан: Даваасүрэн сайдын ярьж байгаа үнэн, үнэн. Ер нь зүгээр төсвийг алдагдалгүй байлгана гэдэг төсвийн сахилга батыг бий болгох, зардлыг багасгах гээд эерэг талтай боловч яг манайх шиг улс оронд асар их сөрөг үр дагаврууд нь илүү давамгай их байгаа юм. Эдийн засаг удаашралтай, зогсонги байгаа үед харин ч төсвөө тэлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг бий болгож, тэгээд орлогоо нэмэгдүүлэх ийм бодлогыг түлхүү барих ёстой. Бид бүх салбар нь хөгжчихсэн, төлөвшчихсэн, тэгширчихсэн, хөгжингүй улс орон биш. Дэлхийд төсвөө алдагдалгүй баталдаг цөөхөн хэдэн улс орон бий. Тэр бол гарын 5 хуруунд ч багтахгүй хэмжээний цөөхөн.

Гэтэл төсвийг бид алдагдалгүй батлах тусмаа эргээд ажлын байр хомсодно, хөрөнгө оруулалт танагдана, магадгүй татварын дарамтууд нэмэгдэнэ. Нөгөө талаараа эдийн засаг тэлэх ямар ч боломж нөхцөлгүй болно. Тэгээд энэ бүхнээ бид тооцож асуудалд хандахгүй бол хэт их хийрхэж, хэт их туйлширч байгаад эдийн засгаа бүр унагаагаад, сүүлд нь төсвийн алдагдалтай төсөв батлаад ч хэдэн жил 5, 10 жил сэхэхээргүй ийм нөхцөл байдал руу орох эрсдэл бий. Нөгөө талаараа төсвөөс гадуурх санхүүжилтийг бид хүссэн, хүсээгүй авч таарна. Гэтэл энэ өөрөө эргээд хяналтгүй, зохицуулалтгүй, уялдаа холбоогүй, орлого зарлага нь хяналтгүйгээр явах эрсдэлүүд давхар бий болоод, 2 хувиар төсвөө танах биш, хэмнэх биш, 20 хувиар илүү алдагдалтай эдийн засгийн нөхцөл байдалд орох эрсдэлүүд бий.

Тэгэхээр энэ удаа төсвийг өргөн барихаас эхлээд, батлах, хэлэлцэх үед хүртэл бид их анхааралтай, их ирээдүйгээ харсан, бодит нөхцөл байдалтайгаа уялдсан байдлаар энэ төсөв санхүүгээ тооцож оруулахгүй бол одоо бол тэр төсвийн тэнцвэртэй байдлыг хангах гэхээсээ илүүтэй төсвөө яаж илүү үр дүнтэй зарцуулах вэ, яаж эдийн засгаа тэлэх вэ, яаж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал дээрээ анхаарах гэдэг Даваасүрэн даргын Төсвийн байнгын хорооны даргын хэлж байгаа саналтай санал нэг байна.

Ц.Даваасүрэн: 2 гишүүн ороод ирвэл санал хураалтаа хийе хэдүүлээ. 8 хүн байж хураагдах ёстой. Хэдүүлээ нэг, тийм болохгүй болчихоод байгаа юм. 2 хүн дуудаадах. Санал хураалт явуулна гишүүдээ, 2 санал хураалт байгаа шүү.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсвийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Үгүй ээ, даргаа сая ахиад энэ төхөөрөмж нь ажилласангүй. Тэгээд би уг нь дэмжиж байгаа байхгүй юу. Тийм учраас тогтоолд дэмжиж байгаагаар тэмдэглэлд оруулж болох уу?

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн дэмжиж байгаа юу? Үгүй ээ үгүй санал хураана, тэгэхгүй болохгүй. Горимын санал гаргачих, санал хурааж байж шийдье, больё, хүчингүй болгочихъё тэгж байж шийдье.

Д.Батбаяр: Сая төхөөрөмж.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Микрофоныг нь өгье, Батбаяр гишүүний микрофоныг өгье дөө. Одоо саналаа гаргачих, горимын санал.

Д.Батбаяр: Төхөөрөмж сая ажилласангүй. Тийм учраас энэ санал хураалтыг хүчингүй болгох, дахиж санал хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна даргаа.

Ц.Даваасүрэн: Энэ яг төхөөрөмжөөс болох нь болоод байгаа юм яалт ч үгүй болчихоод байгаа юм. Ингээд хэдүүлээ Батбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 16-аас 9 гишүүн дэмжиж, 56,3 хувиар өмнөх санал хүчингүй боллоо.

Дахиад санал хураалт явуулна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 16-аас 11 гишүүн дэмжиж, 68,8 хувийн санал дэмжигдлээ.

2 дахь санал. Дээрх хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичгийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргаарай. Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл. Хугацаандаа багтахгүй байгаад байна уу? Горимын санал Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Энэ төхөөрөмжийн алдаа бид нарынх биш гээд. 12 секунд, тэгээд эхлэхээсээ эхэлсэн хойноо нөгөө дохио өгөөд байна. Тэгэхээр асахгүй, эсвэл хоцорчхоод байна. Дахья, горимын санал гаргаж байна, саналыг дахиж хураая.

Ц.Даваасүрэн: Өмнөх саналыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг Мөнхсоёл гишүүн гаргаж байгаа юм байна. Горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 16-аас 10 дэмжиж, 62,5 хувиар өмнөх санал хүчингүй боллоо. Гишүүдээ одоо анхааралтай хураана шүү нэг л хураана. Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 16-аас 9 хүн дэмжиж, 56,3 хувиар тогтоолын төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ. Мөнхтулга гишүүн, Болормаа гишүүнийг дэмжсэнээр авлаа. Дараагийн асуудалдаа орёе. Чуулганд танилцуулахад Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 төсвийн хүрээний мэдэгдэл, 3Г-ын өрийн удирдлагын 26, 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ? Болормаа гишүүн танилцуулъя. Болормаа гишүүн танилцуулахаар боллоо. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөлөл, Засгийн газрын 26, 28 оны стратегийн баримт бичгийг батлах тухай тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Одоо Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтарч хуралдана. Хамтарч ирцээ бүрдүүлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

